

**“Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг
тогтворжуулах (SIFS) дэд хөтөлбөр”-ийн зээлийн
шугамын 14 дэх ашиглалт гарлаа**

Монголбанкнаас жижиглэнгийн нефтийн бүтээгдэхүүнийг хамгийн бага зардлаар санхүүжүүлэхийн зэрэгцээ хил дээрх өртгийн ханшаас хамаарах нөлөөллийг бууруулж, жижиглэнгийн борлуулалтын үнийг тогтвортой байлгах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор SIFS дэд хөтөлбөрийг Уул уурхайн яамтай хамтран 2012.10.26-ны өдрөөс хэрэгжүүлж байгаа билээ.

Энэхүү дэд хөтөлбөрийн 14 дэх транчаар хөтөлбөрт оролцогч банкаар дамжуулан **“Магнай трейд” ХХК**-д жилийн 3.8%-ийн хүүтэй, 1 жилийн хугацаатай **13.9** тэрбум төгрөгийн санхүүжилтийг 5 дугаар сарын 15-ны өдөр шилжүүллээ.

Түүнчлэн дэд хөтөлбөрт заасны дагуу Монголбанк нь оролцогч банкаар дамжуулан 5 дугаар сарын 15-ны өдөр “Магнай трейд” ХХК-тай нийт **13.9** тэрбум төгрөгтэй тэнцэх ам.долларыг **2** сарын дараа худалдах форвард хэлцлийг хамгийн бага зардлаар гүйцэтгэж, ханшийн эрсдлийг нь буурууллаа.

Ийнхүү SIFS дэд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэгч **12** компани нь 2013.05.15-ны өдрийн байдлаар нийт **190.5** тэрбум төгрөгийн зээлийн шугамыг ашиглаад байна.

Дэд хөтөлбөрийн өмнөх санхүүжилт болон хөтөлбөрийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Монголбанкны цахим хуудасны [“Үнийг тогтворжуулах хөтөлбөр”](#) цэснээс үзнэ үү.